

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ
(албан тушаал)

Х.НЯМБААТАР
(нэр)

Тамга

.....
(огноо)

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА
(албан тушаал)

М.БАЯРАА
(нэр)

.....
(гарын үсэг)

Тамга

.....
(огноо)

ТАЙЛАГНАСАН:

“УЛААНБААТАР ЛИФТ” НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДАРГА
(албан тушаал)

Д.ГАН-ЭРДЭНЭ
(нэр)

2023.12.08
(огноо)

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ



“УЛААНБААТАР ЛИФТ” НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗРЫН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги үндэслэж бодлогын баримт бичиг, хууль ТОГТООМЖ	Төсөв (мян. Төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэт- гэлийн хувь
Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 1. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөө							
Зорилт 1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинэчлэгдэж буй цахилгаан шатны захиалагчийн хяналт хийх ажлыг зохион байгуулна.							
1	Арга хэмжээ-1.1 Нийтийн зориулалттай орон сууцны барилгын ашиглалтын шаардлага хангахгүй цахилгаан шатыг шинэчлэх ажлыг үргэлжлүүлнэ. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ажилд захиалагчийн хяналт тавьж ажиллахдаа холбогдох хууль, журамд нийцүүлэн, үнэн зөв, бодитой тайлагнаж, мэргэжлийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулан, тулгамдсан асуудлыг тухай бүр шийдвэрлэж, хөрөнгө оруулалтын ажлын	1,800,000.0 Нийслэлийн төсөв	Ажил гүйцэтгэх гэрээ байгуулснаас хойших гүйцэтгэл, тоо	51	24	1. Нийслэлийн төсөв, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 он дамжин хэрэгжсэн нийтийн зориулалттай орон сууцны барилгын 20 цахилгаан шат шинэчлэлийн ажил 100 хувь бүрэн хэрэгжиж улсын комисст хүлээлгэн өгсөн. 2. Нийслэлийн төсөв, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжиж буй нийтийн зориулалттай орон сууцны барилгын 8 цахилгаан шат шинэчлэлийн ажил: - Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/105 захирамжийн хүрээнд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинэчлэгдэх 4 цахилгаан шатны	90%

	гүйцэтгэлийн бүх үе шатанд тавих хяналтыг сайжруулж, хүнд суртал гаргахгүй ажиллана. (НХТЖҮЧ-9.8.3, НЗДҮАХ-6.1.10, НХТ-5.1.41)				шинэчлэлийн ажлыг гүйцэтгэхээр "Оакс экспресс Монголиа" ХХК шалгарч, гэрээний дагуу цахилгаан шатны угсралтын ажил 100 хувь хийгдэж 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр улсын комисст хүлээлгэж өгсөн. - Нийслэлийн Засаг даргын А/966 дугаар захирамжийн хүрээнд хэрэгжиж буй Нийтийн зориулалттай орон сууцны 2 цахилгаан шатны шинэчлэлтийн ажлыг "Оакс экспресс Монголиа" ХХК нь 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэх гэрээ байгуулж, цахилгаан шатыг захиалсан байна. - Нийслэлийн Засаг даргын А/966 дугаар захирамжийн хүрээнд хэрэгжиж буй Нийтийн зориулалттай орон сууцны 2 цахилгаан шатны шинэчлэлтийн ажлыг "Фүшили элеватор" ХХК нь 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэх гэрээ байгуулж, цахилгаан шатыг захиалсан байна.	
2	Арга хэмжээ-1.2 Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн Газрын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд Улаанбаатар хотод ашиглалтын шаардлага хангахгүй болон ашиглалтын	-	Ажил гүйцэтгэх гэрээ байгуулснаас хойших гүйцэтгэл, тоо	90	Тус төслийн зээлийн эргэн төлөлт нь тодорхойгүй, цаг үеийн нөхцөл байдал (дайны нөхцөл)-аас шалтгаалан хэрэгжих нь тодорхойгүй болоод байна. Нийслэлийн хэмжээнд ашиглалтын шаардлага хангахгүй лифтнүүдийг шинэчлэх төслийг боловсруулж,	-

	хугацаа дууссан, эвдэрч зогссон цахилгаан шатыг шинэчлэх ажлыг хэрэгжүүлнэ.						Нийслэлийн захирагчийн ажлын алба болон Японы Засгийн газрын Koica санд хүргүүлсэн.	
3	Арга хэмжээ-1.3 Улс, нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2023 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж хугацаанд нь чанартай гүйцэтгэнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100		Нийслэлийн төсөв, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022-2023 онд хэрэгжиж буй 8 багц ажлын 20 цахилгаан шатны угсралтын ажлын явцад захиалагчийн хяналтыг тавьж ажилласан. Мөн 2023 онд хэрэгжиж буй 6 багц ажлын 8 цахилгаан шатны угсралтын ажлын явцад захиалагчийн хяналтыг тавин ажиллаж байна. - Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/105 дугаар захирамжийн хүрээнд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинэчлэгдэх 4 цахилгаан шатны ажлыг "Оакс экспресс Монголиа" ХХК гүйцэтгэж, улсын комисст хүлээлгэж өгч байнгын ашиглалтад оруулсан тул гэрээний дагуу санхүүжилтийг олгосон. - Мөн 2021 онд хэрэгжсэн 7 багц ажлын чанарын баталгааны 5 хувийн барьцаа хөрөнгийг чөлөөлж гүйцэтгэгчийн дансанд шилжүүлээ.	100%
4	Арга хэмжээ-1.4 Нийтийн зориулалттай орон сууцны ашиглалтын шаардлага хангахгүй байгаа 132 лифтнүүдийн судалгааг 2023 оны эхний улирлын байдлаар шинэчлэн гаргаж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтэст	-	Ашиглалтын шаардлага хангахгүй байгаа лифтнүүдийн судалгааг	1	1		Нийтийн зориулалттай орон сууцны ашиглалтын шаардлага хангахгүй байгаа 132 лифтнүүдийн судалгааг 2023 оны эхний улирлын байдлаар шинэчлэн гаргаж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтэст	100%

			хүргүүлсэн байдал, тоо			https://erp.ulaanbaatar.mn/ цахим сайтаар хүргүүлсэн.	
Зорилт 2. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт							
5	Арга хэмжээ-2.1 Байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана. (НЗДҮАХ-4.1.4)	-	Мэдээллийг байршуулсан тоо	2	2	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын http://ublft.ub.gov.mn/ цахим хуудсанд тогтмол баяжуулалтыг хийж, иргэд, олон нийтийн оролцоог ханган ажиллаж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 81 мэдээ, мэдээллийг байршуулсан байна.	100%
						Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар заалтад заасан Нээлттэй мэдээллүүдийг байгууллагын цахим хуудаст байршуулсан талаарх явцын мэдээллийг Нийслэлийн Засаг даргын тамгын газарт solongo.m@ulaanbaatar.mn цахим шуудангаар 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр хүргүүлсэн. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт- шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр цахим сайтын нийтийн мэдээллийн ил тод байдлын үнэлгээг хийж, 100 хувийн биелэлттэй үнэлэгдсэн.	
						Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт цахим хуудасны ил тод байдлыг 98	

						шалгуур үзүүлэлтээр үнэлж, 2023 оны 06 дугаар 16-ны өдөр хүргүүлсэн.	
6	Арга хэмжээ-2.2 "Цахим Улаанбаатар" төсөл, "digital first" аяны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, цахим хөгжлийн багц хуулийг сурталчлан таниулах, хуульд заасны дагуу нээлттэй өгөгдөл, мэдээлэл, нийтийн мэдээллийн сангийн хэрэгжилтийг хангуулна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	"Цахим Улаанбаатар" төсөл, "digital first" аяны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, цахим хөгжлийн багц хуулийг байгууллагын цахим хуудсанд байршуулан нийт ажилтнуудад сурталчлан таниулж, хуульд заасны дагуу нээлттэй өгөгдөл, мэдээлэл, нийтийн мэдээллийн сангийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
7	Арга хэмжээ-2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл, бүтэц, зохион байгуулалт, харилцах утас, үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчилнэ.	-	Мэдээллийг байршуулсан тоо	3	3	2023 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын www.ublft.ub.gov.mn цахим хуудсанд танилцуулга, зорилго, зорилт, ажилтнуудын э-мэйл хаяг, харилцах утасны жагсаалт зэрэг мэдээллийг шинэчлэн байршуулсан. Цаг үеийн болон бусад 81 мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна.	100%
8	Арга хэмжээ-2.4 Үзүүлж байгаа ажил үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг тухай бүр цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулна.	-	Мэдээллийг байршуулсан тоо	20	20	Байгууллагаас үзүүлж буй ажил, үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг ublft.ub.gov.mn цахим хуудаснаа байршуулан тухай бүрд шинэчилж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын www.ublft.ub.gov.mn цахим хуудсанд үйл ажиллагаа, төсөв	100%

						санхүү, хүний нөөцийн ил тод байдалтай холбоотой нийт 55 мэдээлэл, мэдээллийн самбарт дээд байгууллагаас ирүүлсэн тогтоол, захирамж, төсөв санхүү, хүний нөөцийн ил тод байдал, сахилга хариуцлага, ёс зүйтэй холбоотой 26 мэдээллийг тус тус байршуулсан.	
9	Арга хэмжээ-2.5 Сул орон тооны зарыг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулж ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Ажлын сул орон тоог байгууллагын www.ublift.ub.gov.mn цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулж ил тод зарлан, сонгон шалгаруулж ажилд авч байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар зарын дагуу иргэдээс анкет болон ажилд орох хүсэлтээ ирүүлснээс 2 иргэнийг Жолоочоор сонгон шалгаруулж ажилд авсан.	100%
10	Арга хэмжээ-2.6 Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээллийн самбартаа байршуулна.	-	Арга хэмжээг ил тод мэдээлсэн байдал, тоо	12	12	"Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталсан бөгөөд 98 хувийн хэрэгжилттэй ажиллаж байна. Зохион байгуулсан арга хэмжээг http://ublift.ub.gov.mn/?cat=45 цахим хуудас болон мэдээллийн самбартаа тухай бүр байршуулдаг ба ажилчдын шуурхай зөвлөгөөн дээр танилцуулан ажиллаж байна.	100%
						Албан хаагчид хийж хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа сар, улирал жилийн	

11	Арга хэмжээ-2.7 Ажилчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар ажилчдын шуурхай зөвлөгөөнөөр мэдээлж ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, тоо	12	12	хугацаатайгаар төлөвлөг ба гүйцэтгэл, үр дүнг ажилчдын шуурхай зөвлөгөөнөөр хэлэлцэн, дүгнэж ажилласан. Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажлын байрны тодорхойлолт болон хөдөлмөрийн гэрээтэй уялдуулан хагас, бүтэн жилийн байдлаар дүгнэсэн.	100%
12	Арга хэмжээ-2.8 Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн мөрдөж, санхүүгийн мэдээ мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулж ажиллана. (НЗДҮАХ-4.1.4.1)	-	Сар бүр мэдээллийг хуулийн дагуу ил тод мэдээлсэн байдал, тоо	24	12	2023 оны төсвийн хөрөнгийн зарцуулалтын дүн мэдээг сар бүр 238 удаа шилэн дансны https://info.shilendans.gov.mn/ цахим хуудсанд байршуулж ил тод мэдээлсэн бөгөөд үйл ажиллагаандаа шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн мөрдөж ажилласан. Үүнээс: Хугацаандаа оруулсан-234 Хугацаа хоцорч мэдээлсэн-4 мэдээлэл байна.	99%
13	Арга хэмжээ-2.9 Дотоодын үйлдвэрлэгчдээс нийлүүлэх боломжтой барааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг баримтлан худалдан авах ажиллагааг зохион байгуулна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжиж “Бат сежү” ХХК-аас 206,400 төгрөгийн ажлын бээлий худалдан авсан. “Алтай заяа” ХХК-аас 1,115,000 төгрөгийн ажлын хувцас худалдан авсан.	100%

	(НХТЖҮЧ-4.1.5, НЗДҮАХ-3.1.4)							
14	Арга хэмжээ-2.10 E-report.mof.gov.mn цахим хуудсанд санхүүгийн тайланг шивж оруулна.	-		Цахим хуудсанд санхүүгийн тайланг оруулсан тоо	1	1	2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр e-report.mof.gov.mn цахим хуудсанд 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг, 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдөр 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг, 2023 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр 2023 оны 03 дугаар улирлын санхүүгийн тайланг тус тус шивж оруулсан.	100%
15	Арга хэмжээ-2.11 Төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, судалгаа, шинжилгээ, ажлын тайлан, холбогдох бусад материалыг албан ёсны цахим хуудсанд нээлттэй байршуулна.	-		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	- Нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 он дамжин шинэчлэгдсэн нийтийн зориулалттай орон сууцны барилгын 20 цахилгаан шат, 2023 онд шинэчлэгдэж байгаа 8 цахилгаан шатны хэрэгжилт, холбогдох бусад мэдээллийг албан ёсны цахим хуудсанд нээлттэй байршуулсан. - Тайлант хугацаанд гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр байхгүй болно.	100%
16	Арга хэмжээ-2.12 Байгууллагын удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтыг хуваарийн дагуу тогтмолжуулж, шийдвэрлэлтийн үр дүнг тооцон, иргэдээс тусгасан санал, хүсэлтийг үйл	-		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Байгууллагын удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтыг хуваарийн дагуу тогтмолжуулж, шийдвэрлэлтийн үр дүнг тооцон, иргэдээс ирүүлсэн (цахимаар, утсаар, албан бичгээр) санал, хүсэлтийг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэн үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.	100%

	ажиллагаандаа ажиллана.	тусган				
17	Арга хэмжээ-2.13 Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхтай холбоотой хууль тогтоомжийг сахин биелүүлнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм", газрын даргын 2021 оны А/33 дугаар тушаалаар албан хаагчийн ёс зүйн дүрмийг шинэчлэн баталсан ба цахим хуудас болон мэдээллийн самбартаа тогмол байршуулан ажиглахаандаа хэрэгжүүлэн, мөрдөж, зөрчил, дутагдалгүй ажиллаж байна. - Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэд олон нийтийг татан оролцуулах, ил тод, нээлттэй байдлыг хангах авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байгууллагын төвлөлөгөөг 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр газрын даргаар батлуулан байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчилж, байгууллагын цахим хуудсанд 5 мэдээлэл, хэвлэмэл хуудсаар 3 мэдээллийг тус тус байршуулсан. - Үйл ажиллагаандаа "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай", "Авлигын эсрэг хуулийг тус тус мөрдөн

						байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй мэдээллийг иргэдэд нээлттэй, хүндрэл чирэгдэлгүй өгөх үүднээс Нийслэлийн эрх зүйн мэдээллийн санд 2017-2023 оны тушаалуудыг байршуулан авлигаас ангид ажиллаж байна.	
18	Арга хэмжээ-2-14 Төрөөс иргэдэд үзүүлэх чанар, үйлчилгээний нэмэгдүүлж, хүртээмжийг цахимжуулах үйлчилгээг үр дүнтэй арга хэмжээ авч, байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулна. (НХТЖҮЧ-5.5.2, НЗДҮАХ-4.2.2.1)	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	2023 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын www.ublft.ub.gov.mn цахим хуудсанд үйл ажиллагаа, төсөв санхүү, хүний нөөцийн ил тод байдалтай холбоотой нийт 55 мэдээлэл, мэдээллийн самбарт дээд байгууллагаас ирүүлсэн тогтоол, захирамж, төсөв санхүү, хүний нөөцийн ил тод байдал, сахилга хариуцлага, ёс зүйтэй холбоотой 26 мэдээллийг тус тус байршуулан байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулж ажилласан.	100%
19	Арга хэмжээ-2.15 Нийслэлийн Засаг даргыг шүүхэд итгэмжлэлээр төлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу оролцох, үр дагаврыг нийслэлийн Засаг даргын өмнө бүрэн хариуцна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Тайлант хугацаанд Нийслэлийн Засаг даргыг шүүхэд итгэмжлэлээр төлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болоогүй болно.	-

20	Арга хэмжээ-2.16 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж зөрчил гаргалгүй ажиллаж байна.	100%
21	Арга хэмжээ-2.17 Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Сургалт, судалгааны төвийн төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх болон ур чадварыг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулагдах аливаа сургалтад холбогдох ажилчдыг хамруулж, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлнэ. (НЗДҮАХ-4.2.3)	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулагдсан сургалтад холбогдох ажилчид хамрагдаж, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлсэн. - Хотын стандарт, хяналтын газраас зохион байгуулсан "Хотын стандарт хэлэлцүүлэг"-т Хяналтын инженер Ц.Уранбилэг, Б.Байгаль нар 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр хамрагдсан. - Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан шинэчлэн батлагдсан Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомж, Архив албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын талаар мэдлэг олгох сургалтад 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр Архив, бичиг хэрэг, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Нарангуа сургалтад хамрагдлаа. - Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан "Засгийн газрын худалдан авах ажиллагааны үндэс" сэдэвт сургалтад	100%

					Хяналтын инженер Ц.Уранбилэг 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдөр хамрагдсан. - Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулагдсан төлбөр тооцооны цахим системийг нэвтрүүлэхтэй холбогдуулан "Төсвийн гүйлгээг цахим системээр хяналт тавих" сэдэвт сургалтад газрын дарга Д.Ган-Эрдэнэ, ахлах нягтлан бодогч З.Ариунтуяа нар хамрагдсан. - Архивын Ерөнхий газраас зохион байгуулсан Албан хэрэг хөтлөлт, архивын ажилтны мэргэжлийн сургалтад 2023 оны 03 дугаар сарын 01-31-ний өдрүүдэд Архив, бичиг хэрэг, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Нарангуа сургалтад хамрагдаж мэргэжлийн үнэмлэх авсан. - Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Бизнесийн процессын дахин загварчлал" сургалтад 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр Архив, бичиг хэрэг, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Нарангуа хамрагдсан. - Монголын барилгачдын нэгдсэн холбооноос зохион байгуулсан Өргөх,
--	--	--	--	--	--

					тээвэрлэх машин, тоног төхөөрөмжийн ашиглалтын мэргэшэх инженерийн багц сургалтад 2023 оны 05 дугаар сарын 15-26-ны өдрүүдэд Хяналтын инженер Б.Байгаль хамрагдаж, мэргэшсэн инженерийн зэрэгтэй болсон. - Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Бусдад харилцаагаар нөлөөлөх нь" сургалтад 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Хүний нөөцийн мэргэжилтэн Ц.Өсөхжаргал хамрагдаж мэргэжлийн ур чадварыг дээшлүүлсэн. - Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан "Хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй" сургалтад 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Хүний нөөцийн мэргэжилтэн Ц.Өсөхжаргал хамрагдаж мэргэжлийн ур чадварыг дээшлүүлсэн. - Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Хууль эрх зүй" сургалтад Ахлах нягтлан бодогч Д.Санжням 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр хамрагдсан. - Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Цахим орчны
--	--	--	--	--	---

						боломж ашиглан ажлын бүтээмжээ нэмэгдүүлэх нь" сургалтад 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Ерөнхий инженер М.Энхбат, Ахлах нягтлан бодогч Д.Санжням, Хүний нөөцийн мэргэжилтэн Ц.Өсөхжаргал, Хяналтын инженер Б.Батзориг, Б.Байгаль, Архив, бичиг хэрэг, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Нарангуа нар хамрагдсан. - Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн гадаад дүр төрх, ёс зүй"-н сургалтад 2023 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр хяналтын инженер Б.Батзориг, жолооч Г.Бадамрагчаа нар хамрагдсан. - Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Судалгааны арга зүй" сургалтад Архив, бичиг хэрэг, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Нарангуа 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлээ. - Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвөөс нутгийн захиргааны байгууллагуудын хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн мэдлэг ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, сайн туршлагаас харилцан суралцах, шилдэг туршлагыг түгээх замаар албан
--	--	--	--	--	--	--

					хаагчдын хөгжлийг дэмжих зорилгоор зохион байгуулсан "Харилцан суралцах арга зүй" сургалтад 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр Хүний нөөцийн мэргэжилтэн Ц.Өсөхжаргал хамрагдлаа. - Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 сургалтын хөтөлбөрийн дагуу Төрийн байгууллага, албан хаагчдад харилцааны соёл, үйл ажиллагаандаа баримтлах дэг, жаягийг нийтлэг байдлаар танилцуулах, анхаарал хандуулах зарим асуудлаар танин мэдэхүйн болон практик мэдээлэл, зөвлөмж өгөх сургалтад 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдөр нийт албан хаагчид цахим хэлбэрээр хамрагдлаа. - Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналт хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй" сургалтад 2023 оны 11 дүгээр сарын 13, 17, 21, 23-ны өдрүүдэд Архив бичиг хэрэг дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Нарангуа, Хяналтын инженер Б.Байгаль, Б.Батзориг, Нярав-Тоо бүртгэгч Б.Уянга, Хүний нөөцийн мэргэжилтэн Ц.Өсөхжаргал нар хамрагдаж гэрчилгээ авлаа.
--	--	--	--	--	--

						- Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүй, гадаад дүр төрх" сургалтад 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр 5 Лифтийн механик хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлээ. - Барилга байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, зөвлөгөөнд 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хяналтын инженер Б.Батзориг, механик инженер Я.Батбаатар нар хамрагдлаа. - Нийслэлийн Архивын газар, "Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ-тай хамтран "Архивын хадгаламжийн нэгж бүрдүүлэх, данс бүртгэл хөтлөх, архивын баримтын хадгалалт хамгаалалт" сэдэвт үзүүлэх сургалтад 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Архив, бичиг хэрэг, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Нарангуа хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлсэн.				
22	Арга хэмжээ-2.18 Байгууллагын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	"Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг 98 хувийн гүйцэтгэлтэй ханган ажиллаж байна.	100%			

						Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээний заалт, холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмыг мөрдөн зөрчил гаргалгүй ажиллуулж байна. Мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулагдсан 5 сургалтад холбогдох ажилчид хамрагдаж, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлсэн. Ажилчдыг ажлын байранд тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд: - Шагнал, урамшуулал, тэтгэмж олгох; - Ажлын үр дүнг, гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажлын байрны тодорхойлолт болон хөдөлмөрийн гэрээтэй уялдуулан үнэн бодитой үнэлж, дүгнэх; - Ажлын ачааллыг оновчтой хуваарилах; - Ажиллах таатай орчныг бий болгох; Хамт олны дунд найрсаг уур амьсгалыг бүрдүүлэх; Хэрэгжилтийн мэдээ тайланг хагас жилээр гарган Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.
						Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Нийслэлийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг

23	Арга хэмжээ-2.19 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Хууль тогтоомжийн хэрэгжилт, хувь	100	100	хэрэгжүүлэхээр 1 зорилтын хүрээнд нийт 2 ажил зохион байгуулж, 97 хувийн биелэлттэй ажиллаж байна. Байгууллагын цахим хуудсанд жендэрийн эрх тэгш байдлын тухай мэдээллийг байршуулан сурталчилж ажилласан. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан Жендэрийн Үндэсний Хорооны Ажлын албанаас зохион байгуулсан "Харилцан хүндэтгэе" аянд идэвхтэй оролцож тайлан мэдээг 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдөр хүргүүлсэн.	97%
24	Арга хэмжээ-2.20 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавин үр дүнг тооцож ажиллана.	-	Үр дүнг тооцож ажилласан байдал, тоо	2	2	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журмын 01 дүгээр хавсралтад заасны дагуу байгууллагын эхний хагас тайланг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд тус тус хүргүүлэн тайлагнасан. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг сар, улирал жилийн хугацаатайгаар төлөвлөдөг ба гүйцэтгэл, үр дүнг тооцон Газрын даргын зөвлөлийн болон	100%

							ажилчдын шуурхай зөвлөгөөнөөр хэлэлцэн, дүгнэж ажилласан. 2023 оны жилийн эцсийн байдлаар 98 хувийн биелэлттэй ажиллаж байна.	
25	Арга хэмжээ-2.21 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнаж ажиллана.	452,058.7 Нийслэлийн төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100		- 2022 оны санхүүгийн 04 дүгээр улирлын тайланг хугацаанд нь гарган холбогдох байгууллагад хүргүүлсэн. 2023 оны 1, 2, 3 дугаар улирлын санхүүгийн тайланг 4 дүгээр сарын 18, 7 дугаар сарын 20, 10 дугаар сарын 20-ны өдөр тус тус Нийслэлийн Санхүү, төрийн санд хүргүүлсэн. - 2023 оны 1-11 дүгээр саруудын Нийгмийн даатгалын тайланг хуулийн хугацаанд нь Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст тушаасан. Тайланг http://app.ndaatgal.mn/ сайтад шивж баталгаажуулсан. - 2022 оны 04 дүгээр улирлын Татварын тайланг, Нийслэлийн Татварын газарт 2023 оны 02 дугаар сарын 10-нд, 2023 оны 1, 2, 3 дугаар улирлын тайланг 2023 оны 4 дүгээр сарын 10, 7 дугаар сарын 10, 10 дугаар сарын 20-ны өдөр тус тус хуулийн хугацаанд нь тайлагнасан. - Татварын 04 дүгээр улирлын тайланг https://www.etax.mta.mn/ сайтад	100%

						2023 оны 02 дугаар сарын 10-нд шивж оруулсан. - 2023 оны 1-11 дүгээр саруудын үйл ажиллагаа болон нэмэлт санхүүжилт, дансны сарын мэдээг гаргаж сар бүрийн 01-нд Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн. Төсвийн хөрөнгийн зарцуулалтын дүн мэдээг сар бүрийн 08-ны өдрийн дотор шилэн http://www.shilendans.ub.gov.mn/home цахим хуудсанд бүртгэж үйл ажиллагаандаа шилэн дансны тухай хуулийг мөрдөн хэрэгжүүлж ажиллалаа.				
26	Арга хэмжээ-2.22 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.	-	Явцын аудитын дүгнэлт, тоо	1	1	- Нийслэл дэх Төрийн аудитын газрын хуваарийн дагуу “Эс Жи Эм Ди” ХХК-аар 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд аудит хийлгэж, 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр зөрчилгүй дүгнэлт гаргуулсан. Зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны 05 дугаар сарын 24, 09 дүгээр сарын 21-ний өдрүүдэд тус тус Нийслэл дэх төрийн Аудитын газарт хүргүүлсэн.	100%			
27	Арга хэмжээ-2.23 Өмч хамгаалах байнгын зөвлөл нь байгууллагын өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдал, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	- Өмч хамгаалах байнгын зөвлөл нь байгууллагын эд хөрөнгийн гэнэтийн болон ээлжит тооллогыг зохион байгуулан эд хөрөнгийн бүртгэлийг нягтлан сайжруулж, эвдэрсэн эд хөрөнгийг Газрын даргын 2023 оны 06	100%			

						дугаар сарын 28-ны өдрийн А/11 дугаар тушаалаар Бараа материал дансанд бүртгэлтэй 3,811,725 төгрөгийн үнэ бүхий ашиглалтын шаардлага хангахгүй материалыг акталж данс бүртгэлээс хасаж өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдал, хадгалалт хамгаалалтад хяналт тавин зөрчил гаргалгүй ажиллаж байна.	
28	Арга хэмжээ-2.24 Чанар байдлаа алдсан үндсэн хөрөнгийг актуулж, данснаас хасах саналыг боловсруулан Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүргүүлж, асуудлыг шийдвэрлүүлнэ.	-	Боловсруулж хүргүүлсэн саналын тоо	1	1	Үндсэн хөрөнгийн тооллогыг төлөвлөгөөт хуваарийн дагуу хийж Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2023 оны 06-р сарын 02-ны өдрийн А/139 дүгээр тушаал, байгууллагын даргын 2023 оны 06-р сарын 28-ны өдрийн А/10 дугаар тушаалын дагуу Эргэлтийн бус хөрөнгөд бүртгэлтэй Тавилга эд хогшил данснаас 517,524 төгрөг, Тоног төхөөрөмж данснаас 3,497,806 төгрөг, нийт 4,015,330 төгрөгийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасав.	100%
29	Арга хэмжээ-2.25 Үндсэн хөрөнгө, хангамжийн материалыг худалдах, шилжүүлэх, устгахад эд хөрөнгийн талаар дүгнэлт гаргана.	-	Гаргах дүгнэлт, тоо	1	1	Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө, хангамжийн материалыг худалдах болон шилжүүлэн устгах үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулж ажилласан болно.	100%

30	Арга хэмжээ-2.26 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 09 дүгээр тогтоолын дагуу хийгдэх "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн үзлэг тооллого"-ыг байгууллагын хэмжээнд зохион байгуулж, дүнг нэгтгэнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, тоо	2	2	Байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, хөрөнгийн данс бүртгэлд тусгасан байдалд хяналт тавих үүднээс эд хөрөнгийн тооллогын ажлыг эхний хагас жилийн байдлаар 2023 оны 06 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд зохион байгуулсан.	100%
31	Арга хэмжээ-2.27 Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, дахин үнэлгээ хийж баталгаажуулна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, тоо	1	1	Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, дахин үнэлгээ хийж баталгаажуулах эд хөрөнгө байхгүй болно. Нийслэлийн Өмчийн харилцааны газраас өмч эзэмшүүлэх гэрээг 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр дүгнэсэн бөгөөд зөвлөмжийн дагуу мод бут, гадна хашааг бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа бараа материалын шинж чанартай хөрөнгийг бараа материалын дансанд шилжүүлэн бүртгэж байна.	100%
32	Арга хэмжээ-2.28 Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн нэгдсэн бүртгэлийн санд хөрөнгийн өөрчлөлтийг хийнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, тоо	1	1	2023 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн нэгдсэн бүртгэлийн санд хөрөнгийн өөрчлөлт болон 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа шивж илгээсэн.	100%
33	Арга хэмжээ-2.29	-	Үйл ажиллагааны	100	100	Тайлант хугацаанд шинээр авсан эд хөрөнгө байхгүй болно.	-

	Шинээр авсан эд хөрөнгийг бүртгэж, эд хариуцагч нарт хүлээлгэн өгнө.		хэрэгжилт, хувь				
34	Арга хэмжээ-2.30 Ашиглалтын хугацаа дуусаж байгаа боловч цаашид ашиглах боломжтой хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хандан дахин үнэлүүлж бүртгэнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Тайлант хугацаанд ашиглалтын хугацаа дуусаж байгаа боловч цаашид ашиглах боломжтой хөрөнгө бүртгэгдээгүй болно.	-
35	Арга хэмжээ-2.31 Төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрөл бүрээр, сар бүр жигд ханган ажиллана.	-	Нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн орлогын хэмжээ	150,223.3	138,000.0	Төлөвлөгөөт зардлын хэтрэлт, хэмнэлт төлөвлөгөөт орлого бүрдүүлэлтийг даргын зөвлөлийн хурал, ажилчдын шуурхай зөвлөгөөн (сар тутамд)-д тухай бүр танилцуулан, шаардлагатай арга хэмжээг авч ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт 130,330,000 төгрөгийн орлогыг Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх байснаас, 183,127,345 төгрөгийн орлогыг төвлөрүүлэн ажилласан. Биелэлт 140 хувьтай байна. Үүнд: Захиалагчийн хяналтаас 46,652,745 төгрөг, техник үйлчилгээнээс 112,414,400 төгрөг, магадлалаас нийт 24,192,200 төгрөгийн орлогыг тус тус бүрдүүлсэн байна.	100%
36	Арга хэмжээ-2.32 "Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө"-ний ажлын	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Байгууллагын "Дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах ажлын төлөвлөгөө"-г 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр байгууллагын даргаар	100%

	хэрэгжилтийг хангаж, үр дүнг тайлагнаж ажиллана.					батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ ажлын төлөвлөгөөнд нийт 16 ажлыг хэрэгжүүлэхээр тусгасан ба 2023 оны жилийн эцсийн байдлаар биелэлт 98 хувийн гүйцэтгэлтэй байна. Дотоод хяналт шалгалтын ажлын тайлан мэдээг 1, 2, 3 дугаар улирлын байдлаар гарган газрын Даргын зөвлөлд тайлагнасан.	
37	Арга хэмжээ-2.33 Байгууллагын дотоод хяналтын үйл ажиллагааг үнэлж, холбогдох арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх замаар байгууллагын дотоод хяналтыг сайжруулна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Байгууллагын дотоод хяналтын үйл ажиллагааг үнэлж, холбогдох арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх замаар байгууллагын дотоод хяналтыг сайжруулан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллаж байна.	100%
Зорилт 3. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт (НЗД-ын 2012 оны А/184 дүгээр захирамж)							
38	Арга хэмжээ-3.1 Засвар, техник үйлчилгээг гэрээгээр хариуцдаг Аж ахуйн нэгж, байгууллага, Сууц өмчлөгчдийн холбоо, иргэдийн цахилгаан шатны засвар, техник үйлчилгээг технологийн дагуу чанартай гүйцэтгэх, графикийг сар бүр гаргаж, ашиглалтын найдвартай ажиллагаа болон аюулгүй байдлыг ханган ажиллана.	-	Техник үйлчилгээ хийсэн лифтийн тоо	1867	1800	Цахилгаан шатанд засвар, техник үйлчилгээ хийж гүйцэтгэх гэрээгээр 60 ААНБ, СӨХ-ны 181 лифтэнд сар бүр графикийн дагуу техник үйлчилгээ хийж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар 60 Аж ахуйн нэгж, байгууллага, Сууц өмчлөгчдийн холбоодын давхардсан тоогоор нийт 1959 цахилгаан шатны засвар, техник үйлчилгээг технологийн дагуу чанартай хийж гүйцэтгэн, графикийг сар бүр гаргаж, ашиглалтын найдвартай ажиллагаа болон аюулгүй байдлыг	100%

						хангаж ажилласан. Мөн хугацаанд гэрээгээр хариуцан ажилладаг 350 лифтийн эвдрэл гэмтлийн дуудлагыг хүлээн авч, лифтийг засварлаж, хэвийн ажиллагаанд оруулж, иргэд оршин суугчдын аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлж ажилласан.	
39	Арга хэмжээ-3.2 Явган хүний гүүрэн гарцын цахилгаан шатны арчлалт, засварын ажлыг гүйцэтгэнэ. (Их тойруу, 100 айлын уулзварын явган хүний гүүрэн гарцын 2, Их тойруу, Бөмбөгөрийн явган хүний гүүрэн гарцын 2, Чингисийн өргөн чөлөө, 120-ийн явган хүний гүүрэн гарцын 2, Чингисийн өргөн чөлөө, 19 дүгээр хорооллын урд талын явган хүний гүүрэн гарцын 2, нийт 8 цахилгаан шатны арчлалт, засварын ажил)	245,800.0 Нийслэлийн төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Нийслэлийн Засаг даргын 2023 оны "Эрх шилжүүлэх тухай" А/200 дугаар захирамжийн хүрээнд гүүрэн гарцуудын цахилгаан шатуудыг 2023 оны 04 дүгээр сарын 15-наас 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл хэвийн найдвартай ажиллуулах бэлтгэл ажлыг ханган лифтынүүдийн өдөр тутмын хэвийн ажиллагааг хариуцан ажиллаж байна. Явган хүний гүүрэн гарцын цахилгаан шатны арчлалт, засварын ажлыг гүйцэтгэх №23/03-20 дугаар гэрээг Нийслэлийн Засаг даргын тамгын газартай байгуулж урсгал засварын ажлыг үе шаттайгаар хийж гүйцэтгэж байна.	100%
40	Арга хэмжээ-3.3 "UB engineering" төслийн Нийслэлийн цахилгаан шатны нэгдсэн хяналтын системийн үйл ажиллагааг хариуцан мэдээллийн санг баяжуулж ашиглалтад нэвтрүүлнэ.	-	Улаанбаатар хотын нэгдсэн мэдээллийн санд баяжуулалт хийсэн цахилгаан шатны тоо	163	2000	"UB ENGINEERING" төслийн мэдээллийн сангийн дата бүрдүүлэх ажлын хүрээнд https://test.ubengineering.gov.mn/ сайтад гэрээт 53 Аж ахуйн нэгж, байгууллага, Сууц өмчлөгчдийн холбооны мэдээлэл, Засаар үйлчилгээ хариуцаж байгаа ААНБ мэдээлэл, болон 150 цахилгаан	100%

						шатны мэдээллийг оруулж, QR кодыг үүсгэн байршуулсан. Мөн өөрийн байгууллагад байгаа бүртгэл, судалгаанд тулгуурлан гэрээгээр хариуцан ажилладаггүй 2000 лифтийн мэдээллийг тус системд оруулж бүртгэлийг үүсгээд байна.	
41	Арга хэмжээ-3.4 Засвар, техник үйлчилгээний гэрээ байгуулан цахилгаан шатны тоог нэмэгдүүлж, үйл ажиллагаагаа өргөжүүлнэ.	-	Гэрээ нэмж байгуулсан цахилгаан шатны тоо	20	20	Тайлант хугацаанд "Дэнж 54" СӨХ-ны 1, "Монта виста 93" СӨХ-ны 1, "Оргил 58" СӨХ-ны 3, "Чандмана" СӨХ-ны 3, "Сансар өргөө" СӨХ-ны 1, "Бадрах" СӨХ-ны 2, "Шинэ хангай" СӨХ-ны 10, "Очир 72" СӨХ-ны 1, "Нарлаг 34" СӨХ-ны 2, "Нийслэлийн онцгой байдлын газар"-ын 4, "Нархан" СӨХ-ны 1, "Баян төгөл" СӨХ-ны 1, "Тэмүүлэл 10" СӨХ-ны 1, "Есөн-Эрдэнэ" СӨХ-ны 1, "Дэвшил 8" СӨХ-ны 1, "Их монгол" СӨХ-ны 2, "Улсын II төв эмнэлэг"-ийн 1 лифт, нийт 37 лифтэнд засвар, техник үйлчилгээ хийж гүйцэтгэх гэрээг шинээр байгуулж ажилласан.	100%
42	Арга хэмжээ-3.5 Цахилгаан шат түүнд тавигдах ерөнхий шаардлагыг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Цахилгаан шат түүнд тавигдах ерөнхий шаардлага стандартыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит бус X хуралдаанаар баталсан. Тус стандартыг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчлан таниулах ажлыг 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Хотын стандарт, хяналтын	100%

						газартай хамтарч Баянгол дүүргийн Сууц Өмчлөгчдийн холбоодын удирдлагуудад танилцуулж ажилласан. Мөн 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Монголын сууц өмчлөгчдийн холбоодын дээд зөвлөлөөс зохион байгуулсан "Танд тусалъя" Нийтийн аж ахуйн салбарын нээлттэй хаалганы өдөрлөгт БЗД-ийн салбар зөвлөлтэй хамтарч "Цахилгаан шат түүнд тавигдах ерөнхий шаардлага" хотын стандартын тараах материалыг СӨХ-дод тарааж, стандартыг танилцуулсан.	
43	Арга хэмжээ-3.6 Газрын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журмын хэрэгжилтэд хяналт тавина.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100		Инженер, механикуудад өдөр тутмын ажлын байран дахь аюулгүй ажиллагааны журмыг мөрдүүлж, ХАБЭА-н тухай "Аюулгүй ажиллагааны 10 дүрэм", "Оффисын аюулгүй байдал", Хувийн хамгаалах хэрэгсэл", "Хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах иргэн, ажилтны эрх үүрэг" зэрэг сэдвээр танилцуулах материал бэлтгэж албан хаагчдад танилцуулж осол авааргүй ажилласан.	100%
44	Арга хэмжээ-3.7 Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны давтан болон өдөр тутмын зааварчилгааг тогтмол өгнө.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100		Лифтний механикуудад өдөр тутмын ажлын байран дахь аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн давтан зааварчилгааг улиралд 1 удаа (2023.02.28, 2023.05.30, 2023.08.31, 2023.11.27-ны өдрүүдэд) өгч,	100%

						Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журмыг мөрдүүлж ажилласан.	
45	Арга хэмжээ-3.8 Инженер, механикуудын хувцас, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангуулж ажиллана.		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Инженер техникийн хэсгийн албан хаагчдыг өвөл, зуны ажлын хувцас, бээлий, нэг удаагийн маск зэрэг шаардлагатай хөдөлмөр хамгааллын хувцсаар хангаж, бүрэн бүтэн байдлыг хангуулан ажилласан.	100%
46	Арга хэмжээ-3.9 Ажлын байран дахь аюул ослыг урьдчилан илрүүлэх, түүнийг гэрээт ААНБ, СӨХ-нд мэдэгдэн арилгах ажлыг тогтмол зохион байгуулна.		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Тайлант хугацаанд гэрээгээр хамтран ажилладаг 25 Аж ахуйн нэгж, байгууллага, Сууц өмчлөгчдийн холбооны 99 лифтэнд техникийн ээлжит магадлалыг хийж, магадлалаар илэрсэн зөрчлийг лифт ашиглагч байгууллагад танилцуулан ажлын байран дахь аюул ослоос урьдчилан сэргийлж, лифтийн аюулгүй найдвартай ажиллагааг хангуулж ажилласан.	100%
47	Арга хэмжээ-3.10 Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр хийж, түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулна.	-	Сэтгэл ханамжийн судалгааг хийсэн тоо	1	4	Гэрээт нийт 50 Аж ахуйн нэгж, байгууллага, Сууц өмчлөгчдийн холбооны дарга, ажилчдаас байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг 2023 оны 02 дугаар сарын 14-20, 06 дугаар сарын 08-14, 09 дүгээр сарын 25-29-ний өдрүүдэд 3 удаа хийсэн. Мөн 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн байгууллагын цахим хуудсаар байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг 04 дүгээр улирлын байдлаар авч байна.	90%

					Судалгаанаас үзэхэд засвар, техник үйлчилгээ үзүүлэх явцад ажилчид ёс зүйн зөрчил гаргасан тохиолдол байхгүй. Механикуудын ажлын ур чадварыг сайн гэж дүгнэсэн. Хэрэглэгчдээс ирүүлсэн санал хүсэлтийг нэгтгэж үзэхэд байгууллага бие даан өргөн хэрэглээний сэлбэг материалтай болох, 24 цагаар дуудлага хүлээн авч, үйлчилгээ үзүүлэх гэсэн саналууд дийлэнх хувийг эзэлж байна. Тус саналын дагуу сэлбэг материалтай болох саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн, сэлбэг материалын нөөц бүрдүүлэх төсөв хөрөнгийн шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.3 дахь хэсэгт заасан төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд олон нийтийн оролцоог хангах зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэлээс хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаанд иргэдийн санал, шүүмжлэлийг тусгаж, төрийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор төрийн үйлчилгээ авч буй иргэн, хуулийн этгээдээс Цахим
--	--	--	--	--	---

						хэлбэрээр авах ажлыг зохион байгуулсан. Мөн үндсэн үйл ажиллагааны үйлчилгээний тоон мэдээллийг 7 хоног бүр Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд udval.b@ulaanbaatar.mn хаягаар хүргүүлсэн.
48	Арга хэмжээ-3.11 Өөрийн эрхлэх чиг үүргийн хүрээнд салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Өөрийн эрхлэх чиг үүргийн хүрээнд салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт шаардлагатай үед нь хүргүүлэн ажиллаж байна.
49	Арга хэмжээ-3.12 Олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу лифтийн техникийн ээлжит магадлалын ажлыг гүйцэтгэнэ.	-	Магадлал хийх лифтийн тоо	365	200	2023 оны жилийн эцсийн байдлаар олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд 87 Аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтийн дагуу гэрээт болон гэрээт бус 376 цахилгаан шатанд техникийн ээлжит магадлалын ажлыг хийж гүйцэтгэсэн.
50	Арга хэмжээ-3.13 Нийслэлийн хэмжээнд ашиглагдаж байгаа болон ашиглалтын хугацаа дууссан, шинэчлэгдэх шаардлагатай лифтийн жагсаалтыг гаргах, бүрэн болон ээлжит магадлалыг цаг алдалгүй хийж, төрийн байгууллагуудын	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Нийслэлийн хэмжээнд ашиглагдаж байгаа болон ашиглалтын хугацаа дууссан, шинэчлэгдэх шаардлагатай 132 лифтийн жагсаалтыг Хотын стандарт, хяналтын газартай хамтран гаргасан. Мөн тайлант хугацаанд 26 Аж ахуйн нэгж, байгууллага, Сууц өмчлөгчдийн холбооны 34 цахилгаан шатны гэмтлийг тогтоож, үүнээс 8 лифтийн гэмтлийн

	хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоог сайжруулж, хамтран ажиллана.					актыг Хотын стандарт, хяналтын газарт хүргүүлэн төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоог сайжруулж, хамтран ажиллаж байна.	
51	Арга хэмжээ-3.14 Хамтран ажиллах гэрээний дагуу шинээр лифтчин бэлтгэх сургалтад иргэдийг бүртгэж, сургалтыг зохион байгуулна.	-	Мэргэжилтэй лифтчин бэлтгэсэн тоо	33	30	"Голден рич одц" ХХК-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд 2023 оны 03 дугаар сарын 24-27-ны өдрүүдэд лифтчин бэлтгэх сургалтыг зохион байгуулж, шинээр 7 лифтчин, 2023 оны 11 дүгээр сарын 25-28-ны өдрүүдэд 5 лифтчинг тус тус бэлтгэж мэргэжлийн үнэмлэх олгосон. Мөн 2023 оны 11 дүгээр сарын 28, 12 дугаар сарын 04-ны өдрүүдэд лифтчингийн үнэмлэхийн хугацаа сунгах давтан сургалтыг зохион байгуулж 12 лифтчингийн үнэмлэхийн хугацааг сунгасан.	80%
52	Арга хэмжээ-3.15 Лифт эзэмшигч, ашиглагч байгууллагуудын удирдлагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө, сургалтыг Монголын сууц өмчлөгчдийн холбоодын дээд зөвлөлтэй хамтран үе шаттайгаар зохион байгуулж, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажиллана.	-	Лифт эзэмшигч, ашиглагч байгууллагуудын удирдлагуудын тоо	30	30	Баянгол дүүргийн лифт эзэмшигч, ашиглагч байгууллагуудын удирдлагуудад 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Хотын стандарт, хяналтын газартай хамтарч Цахилгаан шат түүнд тавигдах ерөнхий шаардлага стандартыг танилцуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Мөн "UB ENGINEERING" төслийн мэдээллийн сангийн дата бүрдүүлэх ажлын хүрээнд Монголын сууц өмчлөгчдийн холбоодын дээд зөвлөлийн холбоотой хамтарч харьяа СӨХ-дод	100%

						мэргэжил арга зүй зөвлөгөө өгч ажилласан.	
Зорилт 4. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт							
53	Арга хэмжээ-4.1 Тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлж, албан бичгийн харилцааг цахимжуулна. (НЗДҮАХ-4.1.1.3)	-	Тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлсэн албан хаагчдийн тоо	1	7	Тоон гарын үсгийг 9 ажилтан хэрэглээнд нэвтрүүлж, 2 тоон гарын үсгийг ашиглалтад нэвтрүүлж, албан бичгийн харилцааг цахимжуулсан. 7 тоон гарын үсгийг нөөцөд авсан байна.	90%
54	Арга хэмжээ-4.2 Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирсэн албан бичгийн шийдвэрлэлт болон нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын систем www.egr.ulaanbaatar.mn цахим хуудсыг хөтлөнө.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн www.egr.ulaanbaatar.mn системийн edoc программд байгууллагад ирсэн албан бичгийг хүлээн авч байгууллагын "Албан хэрэг хөтлөлтийн журам"-ын дагуу ангилан бүртгэж, холбогдох ажилтанд шилжүүлэн ажиллаж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 375 албан бичиг бүртгэгдсэнээс 66 хариутай албан бичиг хүлээн авсан ба тухай бүр хугацаанд нь хариу өгч шийдвэрлэж ажилласан. Нийт явуулсан албан бичиг 237 байна. Албан бичгийн шийдвэрлэлтийн байдалд болон хариутай албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж байгаа эсэхэд	100%

						тогтмол хяналт тавин зөрчил гаргалгүй ажилласан.	
55	Арга хэмжээ-4.3 Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг зохион байгуулна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Байгууллагын архивын 2012-2020 оны байнга хадгалах болон тусгай төрлийн баримтыг Нийслэлийн Архивын газарт шилжүүлсэн. Шинэчлэн батлагдсан журмын дагуу албан хэрэг хөтлөлтийн ажлыг зохион байгуулж ажилласан. - 2023 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг байгууллагын нийт албан хаагчаас санал авч байгууллагын дэргэдэх Баримт нягтлан шалгах комиссын 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн №01 дугаар хурлаар хэлэлцэж нийт 74 хадгаламжийн нэгж баталсан. - 2023 оны 03 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд ажилтнуудаас баримт бичиг хүлээн авах графикийн дагуу байгууллагын 2022 оны үйл ажиллагааны явцад үүсэж хөтлөгдсөн баримт бичгүүдээр ХХНЖ-ын дагуу хэрэг бүрдүүлэх ажлыг зохион байгуулсан. Нийт 107 хадгаламжийн нэгж үүссэнээс 70 жил хадгалах-5, түр хадгалах-52, байнга хадгалах-50 баримтыг тус тус ангилан төрөлжүүлж хэрэг бүрдүүлсэн. - Нийслэлийн Архивын газрын дэргэдэх Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр хурлаар батлагдсан. байнга хадгалах 224	100%

						хадгаламжийн нэгж, тусгай төрлийн баримтыг шилжүүлсэн. - Нийслэлийн архивын газрын Archive Edoc программд 2022 онд үүсэж хөтлөгдсөн Захирамжлалын 45 баримт бичгийг агуулга тодорхойлон шивж бүртгэлд оруулсан. Захирамжлалын нийт 45 баримтыг http://erp.ulaanbaatar.mn нэгдсэн сайтын ArchiveEdoc системд агуулга тодорхойлон үндсэн үйл ажиллагааны асуудлаар гаргасан даргын А тушаал 32, Хүний нөөцийн асуудлаар гаргасан даргын 13 Б тушаалыг шивж оруулсан байна.				
56	Арга хэмжээ-4.4 Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдлыг хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгч хэвших, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгайлсан арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж ажиллана.	-		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Тайлант хугацаанд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн нийт 13 өргөдөл гомдол, хүсэлтийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн ажилласан. Иргэд аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн чанар, үр дүнг сайжруулж хуулийн хугацаанд нийслэлээс дэвшүүлсэн зорилтот түвшинд шийдвэрлэсэн. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын 03 дугаар улирлын шийдвэрлэлтийн мэдээг 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.	100%		

ДУНДАЖ ХУВЬ:	98%
--------------	-----

Төсвийн Ерөнхийлөн захирагч

Тайланг хянасан:
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН

ЗАХИРАГЧ Х.НЯМБААТАР

(огноо)

Тайлагнасан
"УЛААНБААТАР ПИФ" ОНӨТҮГ-ЫН
ДАРГА Д.ГАН-ЭРДЭНЭ

